



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

“Маркентайл хаус азиа ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, 14.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.5.6, 10.5.9 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Маркентайл хаус азиа ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” гэсэн тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлүүлэхийг “Маркентайл хаус азиа ББСБ” ХХК /Жоел Каше/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001769